



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар

А/1199

Номгон

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл
ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, 11.1.4, 11.1.8, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 7.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхонгор сумын өрхийн эрүүл мэндийн төвүүд нь "Ковид-19" цар тахлын хүнд хэцүү цаг үед халдварын тархалтыг хумих, эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг идэвх санаачилгатай зохион байгуулан ажиллаж байгаа тул шаардлагатай нэмэлт санхүүжилтийг олгосугай.

2. Оточмандал, Оточномгон, Энхбүрд, Наранмандал өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай байгаа 40.000.000 (дөчин сая) төгрөгийн дэмжлэгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хамтран ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210155